



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар A/1470

Улаанбаатар хот

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.12, 4.14, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 1.3, 2.1, 2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:

Дүүргийн Засаг дарга

Гишүүд:

Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч

Дотоод аудитын албаны дарга

Хөндлөнгийн гишүүн (зөвшилцсөнөөр, МНБ)

Хөндлөнгийн гишүүн (зөвшилцсөнөөр, МНБ)

2.Дотоод аудитын хорооны нарийн бичгийн даргаар Дотоод аудитын албаны Ахлах дотоод аудиторыг томилсугай.

3.Үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажиллаж, дотоод аудит, хяналт шалгалтын тайланг Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулж, биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын алба (Н.Наранчимэг)-нд даалгасугай.



Ө.СУМЪЯАБААТАР